



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

5-Р САР

Э-сонин

58-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.05.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	23
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	11,932,327,597.03
Хувьцаа /анхдагч/	6,431,538,000
Хувьцаа /хоёрдогч/	4,400,118,257.03
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	604,171,340
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	496,500,000
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	45,523,477
Хувьцаа /анхдагч/	16,925,100
Хувьцаа /хоёрдогч/	28,593,412
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	5,866
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	4,965
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	8,684


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	220
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	189
I ангилал	9
II ангилал	41
III ангилал	170

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	59
Үүнээс:	
Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.05.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Гаули ХХК	2,063,425	771,323,649.84	1,850,649	445,107,882.22	1,216,431,532.06
2	Бумбат-Алтай ХХК	2,501,239	569,971,201.08	4,841,166	475,471,727.23	1,045,442,928.31
3	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	16,791,742	883,257,526.91	5,855,558	348,635,813.00	1,231,893,339.91
4	БиДиСек ХК	883,057	407,494,151.10	1,991,187	512,487,028.96	919,981,180.06
5	Ти Ди Би Капитал ХХК	1,068,248	277,758,629.79	2,153,841	367,142,403.61	644,901,033.40
6	Голомт Капитал ХХК	2,093,178	344,412,172.98	1,223,316	272,591,515.65	617,003,688.63
7	Стандарт инвестмент ХХК	747,687	259,897,900.10	3,061,557	295,132,813.50	555,030,713.60
8	Новел инвестмент ХХК	201,369	74,842,447.55	2,212,593	370,855,709.48	445,698,157.03
9	Ард капитал групп ХХК	316,210	175,997,665.28	165,126	175,575,541.01	351,573,206.29
10	Ард секюритиз ХХК	698,879	126,435,175.65	734,695	201,828,008.37	328,263,184.02
11	Санар ХХК	4,941	4,656,271.00	404,529	185,344,329.70	190,000,600.70
12	Евразиа капитал монголиа ХХК	172,669	63,976,854.00	414,200	103,345,282.70	167,322,136.70
13	Тэсо инвестмент	74,443	88,209,856.64	394,270	72,518,716.81	160,728,573.45
14	Блүмсбюри секюритиес ХХК	219,801	23,101,095.28	400,512	95,405,749.31	118,506,844.59
15	Дэлгэрхангай секюритиз ХХК	78,559	102,379,550.00	41,683	12,067,488.00	114,447,038.00
16	Батс ХХК	157,475	33,809,244.02	887,581	72,619,017.10	106,428,261.12
17	БиДиСек ХК	41,715	1,949,082.50	145,000	61,344,500.00	63,293,582.50
18	Монсек ХХК	99,968	8,527,054.13	295,603	42,101,154.63	50,628,208.76
19	Таван богд ХХК	20,543	17,321,922.00	23,941	31,921,540.88	49,243,462.88
20	Нэйшнл сэкюритис ХХК	25,308	45,169,075.00	462	449,279.90	45,618,354.90

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.05.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт %/
1	MBW	Монгол Базальт ХК	3,777,486	1,571,389,908.98	436.00	400.00	413.12	0.00
2	LEND	ЛэндМН ББСБ ХК	22,094,315	1,067,505,199.23	54.20	42.01	9.15	21.75
3	APU	АПУ	903,710	545,445,432.16	654.00	561.00	-2.70	-0.43
4	TTL	ТАВАН ТОЛГОЙ	30,807	298,777,730.00	10,480.00	9,190.00	-170.00	-1.67
5	GOV	ГОВЬ	11,179	244,242,000.00	24,000.00	21,000.00	900.00	4.09
6	JIV	ЖИНСТ-УВС	78,612	121,103,180.00	1,700.00	1,450.00	-200.00	-11.76
7	GTL	ГУТАЛ	3,614	79,362,000.00	22,620.00	19,000.00	2,500.00	12.82
8	SUU	СҮҮ	311,020	66,629,961.17	230.00	200.00	19.03	9.27
9	GFG	Силк нет	72,564	52,531,998.00	724.50	615.90	-118.67	-16.16
10	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	535	50,077,560.00	100,000.00	76,700.00	-500.00	-0.50
11	BAN	БАГАНУУР	19,368	37,271,809.00	2,100.00	1,900.00	-11.00	-0.58
12	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	61,703	35,165,258.00	590.00	543.00	-28.00	-4.68
13	ITLS	АЙТҮҮЛС	272,860	34,608,267.60	154.50	117.00	6.00	4.62
14	BDS	БИ ДИ СЕК	22,518	24,774,979.00	1,200.00	1,000.00	95.00	9.03
15	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	189,857	17,664,752.98	95.00	80.00	4.09	4.82
16	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	42,263	16,363,915.00	9,305.00	107.00	-7,971.95	-98.48
17	RMC	РЕМИКОН	349,524	15,833,950.66	48.90	40.00	-1.08	-2.45
18	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	26,957	13,678,790.00	548.00	470.00	-5.00	-0.99
19	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	1,237	11,802,720.00	10,920.00	9,500.00	1,420.00	14.95
20	TAN	ТАХЬ-КО	536	8,576,000.00	16,000.00	16,000.00	0.00	0.00



Үнэт цаасны зах зээл

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт %/
			2018-05-01	2018-05-31		
1	АЛТАЙН ЗАМ	10	603.79	2,439.00	1,835.21	303.95
2	УСЖУУЛАХ	1,132	250.00	551.01	301.01	120.40
3	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	12	107.88	164.05	56.17	52.07
4	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	42,263	93.30	123.05	29.75	31.89
5	АВТО ЗАМ	78	4,101.00	5,180.00	1,079.00	26.31
6	ЛэндМН ББСБ ХК	22,094,315	42.06	51.21	9.15	21.75
7	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	617	419.00	500.00	81.00	19.33
8	НАКО ТҮЛШ	600	126.50	148.52	22.02	17.41
9	ТЭЭВЭР-АЧЛАЛ	22	800.00	920.00	120.00	15.00
10	МОГОЙН ГОЛ	131	8,000.00	9,200.00	1,200.00	15.00
11	БИНСЭ ХК	40	350.00	402.50	52.50	15.00
12	БАЯЛАГ НАЛАЙХ	119	205.00	235.75	30.75	15.00
13	ДОРНОД ИМПЕКС	2	105.00	120.75	15.75	15.00
14	ГАН ХИЙЦ	15	11,800.00	13,570.00	1,770.00	15.00
15	ӨНДӨРХААН	5	9,600.00	11,040.00	1,440.00	15.00
16	ОРХОНДАЛАЙ	18	3,100.00	3,565.00	465.00	15.00
17	ТАЛЫН ГАЛ	349	13.80	15.87	2.07	15.00
18	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,035	302.10	347.41	45.31	15.00
19	ДОРНОД ХУДАЛДАА	5	17,480.00	20,100.00	2,620.00	14.99
20	ГАН ХЭРЛЭН	2	2,903.00	3,338.00	435.00	14.98

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.05.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-05-01	2018-05-31		
1	СИЛК НЭТ	72,564	734.57	615.90	-118.67	-16.16
2	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	2,586	100.00	85.00	-15.00	-15.00
3	ХӨХ ГАН	24,199	100.00	85.00	-15.00	-15.00
4	ШИВЭЭ ОВОО	460	2,395.00	2,051.00	-344.00	-14.36
5	АВТО ИМПЕКС	237	2,500.00	2,200.00	-300.00	-12.00
6	ЖИНСТ-УВС	78,612	1,700.00	1,500.00	-200.00	-11.76
7	УВС ЧАЦАРГАНА	279	1,100.00	980.00	-120.00	-10.91
8	МЕРЕКС	96,187	33.50	30.00	-3.50	-10.45
9	ШАРЫН ГОЛ	348	2,448.00	2,203.00	-245.00	-10.01
10	ЦАГААНТОЛГОЙ	37	2,700.00	2,450.00	-250.00	-9.26
11	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	23,536	218.00	199.00	-19.00	-8.72
12	МИК ХОЛДИНГ	29	11,250.00	10,500.00	-750.00	-6.67
13	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	227	34,000.00	32,000.00	-2,000.00	-5.88
14	МОНГОЛ ШУУДАН ХК	61,703	598.00	570.00	-28.00	-4.68
15	ХАР ТАРВАГАТАЙ	5	11,000.00	10,500.00	-500.00	-4.55



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА АМЖИЛТТАЙ БОЛЛОО

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК дээр 2018 онд хийгдэж буй хоёрдахь IPO болох “Монгол Базальт” ХК нь нийт хувьцааны 30% буюу 16,925,100 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс өнөөдөр буюу 05 дугаар сарын 23-ны өдрийн 13:00 цаг хүртэл авч дууслаа.

“Монгол Базальт” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 3,086 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 53,562,855 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 3.1 дахин давсан үзүүлэлт боллоо.

Тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр эхлүүлээ.

ҮНЭТ ЦААСНЫ АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛ ЗӨВШӨӨРӨГДЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа давхар бүртгүүлэхээр хүсэлт гаргасан Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD) -ийн 1.2 сая канад долларын үнийн дүн бүхий 4,000,000 ширхэг хүртэл энгийн хувьцааг бүртгэхийг зөвшөөрлөө.

Ийнхүү, Монголын хөрөнгийн зах зээлд цоо шинэ бүтээгдэхүүн нэвтэрч байгаа нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй 30 гаруй уул уурхайн компаниуд Монгол улсад үнэт цаасаа гарган арилжих, эдгээр компанийн хувьцааг ард иргэд, олон нийт эзэмшиж, байгалийн баялгийн үр шимийг хүртэх боломжийг нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг нэгэн шатаар ахиулж, дэлхий нийтийн жишиг хандлагын дагуу хөгжүүлэхэд түүхэн чухал ач холбогдолтой үйл явдал болж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ ШИНЭЧЛЭГДСЭН ЖУРМУУДЫН ТӨСЛИЙГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхэд “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчимд суурилсан төлбөр тооцооны Т+2/3 горимыг эргэн нэвтрүүлэх ажил нэн тулгамдаад байгаа билээ.

Энэхүү ажлын хүрээнд 2017 оны 4 дүгээр сард “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар ахлуулсан ажлын хэсгийг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүрэлдэхүүнтэй байгуулж, “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчимд суурилсан Т+2/3 горимыг хэрэгжүүлэхээр ажиллаж эхэлсэн билээ. Тус ажлын хэсгийн хүрээнд, үнэт цаасны төлбөр тооцооны Т+2/3 горимд шилжихэд шаардлагатай 6 багц журмыг шинээр боловсруулан нийт гишүүн үнэт цаасны компаниудад танилцуулж хэлэлцүүлсэн бөгөөд 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр эдгээр журмуудын төслийг батламжлуулахаар Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлээ.

Уг шинэчлэгдсэн журмууд батлагдсанаар урьдчилсан төлбөрт системийг халж дараа төлбөрт системд шилжих, “Арилжааны төлбөр тооцоо” ХХК нь анхдагч болон хоёрдогч зах зээлийн төлбөр тооцоог гүйцэтгэдэг болох, тооцооны гишүүнчлэлийг бий болгох, зах зээлийг эрсдлээс хамгаалах зорилго бүхий Төлбөрийн баталгааны санг үүсгэн байгуулах зэрэг гол өөрчлөлтүүд зах зээлд хэрэгжиж эхлэх бөгөөд улмаар олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын гарц нээгдэх, Монгол улс олон улсад танигдсан “Фронттиер” зах зээлийн зэрэглэлтэй болж, олон улсын жишгийн дагуу өсч хөгжихөд том түлхэц болох юм.

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааг хувааж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагаа “ҮЦТХТ” ТӨХХК-д хийгдсэн тул СЗХ-ны Улсын байцаагчийн 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 35 тоот албан шаардлагын дагуу “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс нээхээр боллоо.



"1072 ХУВЬЦАА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ" НЭЭГДЛЭЭ

"Эрдэнэс-Таван толгой" ХК нь 1072 хувьцааны арилжаа эхлэхээс өмнө иргэд, олон нийтийн хувьцааны талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор "1072 хувьцаа мэдээллийн төв"-ийг албан ёсоор ажиллуулж эхэллээ. Тус төв нь 1072 хувьцаатай холбоотой иргэдийн сонирхсон асуултуудын хариултыг газар дээр нь өгөхөөс гадна "1072 хувьцаа мэдээллийн төв Facebook хуудас" болон 1800-1072 тусгай дугаараар иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж байна. "1072 хувьцаа мэдээллийн төв" нь ажлын өдөр бүрийн 08.30-17.30 цагийн хооронд ажиллах бөгөөд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8 гудамж буюу "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн хойд байрны 106 тоотод байрлаж байна.

"ТЭЭВЭР ДАРХАН" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Тээвэр Дархан" ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын 2018 оны 4 дугаар сарын 27-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 500 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож, 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор олгохоор шийдвэрлэсэн байна.

"МОНГОЛ АЛТ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Монгол Алт" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 150 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож, ноогдол ашгийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор олгохоор шийдвэрлэсэн байна.

"ЖИНСТ УВС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Жинст Увс" ХК нь 2018 оны 4 дугаар сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа "Жинст Увс" ХК-д "Ард санхүүгийн нэгдэл" хаалттай ХК-ийг нэгтгэхээр шийдвэрлэсэн байна.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-д заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн огноо: **2018 оны 4-р сарын 28-ны өдөр** Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: **2018 оны 6-р сарын 15-ны өдөр** Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: **1,547 төгрөг**

Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол "Жинст Увс" ХК болон "Ард Секюритиз ҮЦК" ХХК-д хандана уу.

Шаардах эрх хэрэгжүүлэгч "Жинст увс" ХК: УБ, СБД, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард санхүүгийн нэгдлийн байр, Холбогдох утас: 11-321899, 86110400, 90001991

"Ард секюритиз ҮЦК" ХХК: УБ, СБД, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард санхүүгийн нэгдлийн байр, Холбогдох утас: 11-321899, 94100304, 88116549

"ТЭСО ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ "АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 332 тоот тушаалаар Монголын хөрөнгийн биржийн гишүүн "Тэсо инвестмент ҮЦК" ХХК-ийн оноосон нэрийг "Апекс капитал ҮЦК" ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн байна.



НЭР БҮХИЙ 55 ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХААС БУСАД БҮРЭН ЭРХ НЬ ДУУСГАВАР БОЛЛОО

Компанийн тухай хуульд зааснаар хувьцаат компани (ХК)-ийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулахаар заасан байдаг. Ингэхдээ дээрх хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам"-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, уг журам болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Энэхүү хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг дараах нэр бүхий 55 хувьцаат компани биелүүлээгүй тул тус компаниудын ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг ээлжит бусаар зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болсныг мэдээлж байна.

Хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш эдгээр ТУЗ-үүдтэй байгуулсан

аливаа гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус болохыг тус ХК-уудын хувьцаа эзэмшигч, удирдлага, харилцагч байгууллага болон бусад холбогдох этгээдүүдэд анхааруулж байна.

1 "АР ТАРХИ" ХК	20 "МУДИКС" ХК	39 "ДУЛААН ШАРЫН ГОЛ" ХК
2 "БАЯНТАЛБАЙ" ХК	21 "ИХ БАРИЛГА" ХК	40 "НИЙСЛЭЛ ӨРГӨӨ" ХК
3 "ЭРДЭНЭТ ЗАНДАН" ХК	22 "СЭЛЭНГЭ СҮРЭГ" ХК	41 "ӨЛЗИЙ-ДУНДГОВЬ" ХК
4 "АЛМААС" ХК	23 "ИХ НУУР" ХК	42 "ХҮНС-АРХАНГАЙ" ХК
5 "АР БАЯНХАНГАЙ" ХК	24 "ИХ ҮҮСГЭЛ" ХК	43 "ШИМ" ХК
6 "БАЯНТООРОЙ" ХК	25 "ӨВ-УСЖУУЛАГЧ" ХК	44 "ЭРДЭНЭТ СУВРАГА" ХК
7 "ДОРНОД" ХК	26 "СЭЛЭНГЭ ИМПЕКС" ХК	45 "БОРНУУР" ХК
8 "МОН-АСАР" ХК	27 "АВТО ЗАМ" ХК	46 "ЦАГААНТОЛГОЙ" ХК
9 "МӨНХ ЖИМ" ХК	28 "АГРОТЕХИМПЕКС" ХК	47 "ДАРХАН МАХ ЭКСПО" ХК
10 "ТӨВ УС" ХК	29 "АЖЛЫН ХУВЦАС" ХК	48 "НОЁТХАЙРХАН" ХК
11 "ХАНГАЛ" ХК	30 "БАЯЛАГ ШАРЫН ГОЛ" ХК	49 "ОРХОНДАЛАЙ" ХК
12 "ХАРГИ" ХК	31 "БҮТЭЭЛ" ХК	50 "МОНГОЛ ДИЗЕЛ" ХК
13 "ЭСГИЙ ГУТАЛ" ХК	32 "ЖИНСТ" ХК	51 "МОНГОЛ КЕРАМИК" ХК
14 "ӨРГӨН ХЭРЭГЛЭЭ" ХК	33 "ХӨДӨӨГИЙН ТЭЭВЭР" ХК	52 "МОНГОЛ ШЕВРО" ХК
15 "ХАРШИЙН ГЭГЭЭ" ХК	34 "ЧАНДМАНЬ ДУНДГОВЬ" ХК	53 "САВ ШИМ" ХК
16 "ХУРТАЙ" ХК	35 "ЧАНДМАНЬ УУЛ" ХК	54 "ХАНЫН МАТЕРИАЛ" ХК
17 "БОРООГИЙН ҮЙЛДВЭР" ХК	36 "АСБИ" ХК	55 "БЭРЭН МАЙНИНГ" ХК
18 "ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС" ХК	37 "БИНСЭ" ХК	

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN